

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР 2014 ОНД ХИЙГДСЭН АЖИЛ

Мөнгөлөг шагшуурга:

2014 оны 02 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд “Мөнгөлөг шагшуурга” цас мөсний баярыг амжилттай зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд, Завхан, Увс, Баян-Өлгий аймгуудын төлөөлөл, БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймгийн төлөөлөгчид, Ховд аймгийн 17 сумын төлөөлөгчид оролцож, ойролцоогоор 15000 гаруй



иргэд үзэж сонирхлоо.



Энэ үеэр урианхай мөсөн сурын харваа, мөсөн дээрхи сумо, олс таталт, гүйлт, тэмээний уралдаан, цэнгээнт бүжгийн тэмцээн, “Дээлтэй монгол хүүхэд” уралдаан зэрэг спорт, урлагийн тэмцээнүүдийг зохион байгуулж шилдгүүдээ шалгарууллаа.

Баруун бүсийн соёл, спорт, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг эрчимжүүлэх нь” сэдэвт сургалт, зөвлөгөөн:

2014 оны 6 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд соёл, спорт, аялал жуулчлалын салбарын төрийн байгууллагын удирдах ажилтан, салбар хариуцсан мэргэжилтэн нарт салбарын бодлого, эрх зүйн орчин, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийн талаархи мэдээллийг олгох, албан хаагчид танилцах, ажлын туршлага солилцох, нэгдсэн удирдлагаар хангах, 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор “Баруун бүсийн соёл, спорт, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг эрчимжүүлэх нь” сэдэвт сургалт, зөвлөгөөн зохион байгуулагдлаа.



Галдан бошигт хааны мэндэлсний 370 жилийн ой, Баруун бүсийн “Их Хурд” наадам:



XVII зууны үеийн Монголын төр, шашны нэрт зүтгэлтэн, тусгаар тогтнолын төлөө тууштэй тэмцэгч Галдан бошигт хааны мэндэлсний 370 жилийн ой, баруун бүсийн “Их хурд” наадмыг ёслол төгөлдөр зохион байгууллаа. Уг ойн үеэр “Галдан бошигт судлал” олон

улсын эрдэм шинжилгээний бага хурал, “Угсаатны бүлгүүдийн өв соёлын наадам”, “Өв соёлоороо гоёцгооё” үндэсний хувцасны уралдааныг зохион байгуулахын зэрэгцээ аймгийн Хөгжимт драмын театрт “Галдан бошгот хаан” туульсийн дуулалт жүжгийг найруулан тоглолоо. Мөн “Галдан бошигт хаан”-ы ёслол хүндэтгэлийн өргөө, нэрэмжит гудамж байгуулж, “Хөх тэнгэрийн бошго” баримтат киног бүтээлээ. Тэрчлэн “Галдан бошигт судлал I, II боть”, “Ховд аймаг: Байгалийн нөхцөл, нөөц, түүх, соёл”, Е.И.Кичановын “Галдан бошигт хааны хүүрнэл” зохиол, зохиолч Д.Жамьяны “Галдан бошигт хаан” романыг тус тус хэвлүүлэв.



“ХОВД-2014” бага олимп:

Ховд-2014 бага олимпыг анх удаа Соёл, спорт, аялал жуулчлалын



яам, МҮОХороо, Ховд аймгийн ИТХ, ЗДТГ, Ховд аймгийн хөгжлийн төлөө сантай хамтран зохион байгуулж 28 багийн 2000 гаруй баг тамирчид хурд, хүч, авхаалж самбаагаа сорьлоо.



“Аварга” хөтөлбөрийг хүрээнд 2014 онд 10 төрлийн спортын секц дугуйланд 500 гаруй тамирчин хамрагдаж, бүс, аймгийн аврага шалгаруулах тэмцээн 10-ийг зохион байгуулж, улсын аврага шалгаруулах тэмцээнд 17 төрлөөр оролцож 301 медаль хүртсэн амжилттай байна.

“АЛТАН ӨВ” соёлын өдрүүд:

Олон үндэстэн, угсаатны бүлгүүдийн түүх соёл, зан заншил, өв уламжлал, соёлыг сурталчлах, нуугдмал авьяастан, үнэт өвийг



нээн илрүүлж, нийтийн хүртээл болгон хөгжүүлэх зорилгоор сумдын “Алтан өв” соёл урлагийн өдрүүдийг амжилттай зохион байгуулж байна.



2014 онд Булган, Дарви, Зэрэг, Мянгад, Дуут, Дөргөн зэрэг сумдын “Алтан өв” соёл урлагийн өдрүүдийг зохион байгууллаа.

“Алтайн дуулал” яруу найраг, богино өгүүллэгийн наадам, Айтыс тэмцээн, Үг, ая, бийрээр урлаачдын аймгийн анхдугаар зөвөлгөөнийг зохион байгуулж, УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэлийн санаачлага ивээлээр “Морин хуурын наадмыг Манхан суманд амжилттай зохион байгуулав. Уг наадамд аймгийн 17 сумын 130 гаруй морин хуурчид хамтлаг, гоцлол төрлөөр ур чадвараа уралдууллаа.

Олон улсын хөөмийн III их наадам:

Олон улсын хөөмийн III наадмыг аймгийн төвд болон Чандмань суманд тусгай хөтөлбөрөөр зохион байгуулж, нийт 8 орны 90-иэд Хөөмийчид оролцлоо.



Энэ үеэр эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, Монгол, ОХУ, АНУ, БНХАУ зэрэг

орнуудын 16 судлаачид илтгэл тавьж хэлэлцүүлэв.



Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зорилгоор Соёл урлагийн их сургуультай сүүлийн 3 жил дараалан хамтран ажиллаж, элсэн суралцуулах элсэлтийг зохион байгуулж одоогийн байдлаар манай аймгаас дуулаач, хөгжим, бүжиг, жүжиг, концертмейстр, соёлын менежмент зэрэг ангиудад 50 гаруй оюутан суралцаж байна. 2013-2014 оны хичээлийн жилд Соёл, урлагийн их сургуульд Концертмейстер, найрал дуу, хөгжмийн багш, менежмент зэрэг ангиудад 11 хүүхдийг, 2014 нийт 9 мэргэжлээр 11 оюутан тус тус элсүүлэн суралцуулж байна.

ХДТ-ын 1 хөөмийч, 2 уртын дуучныг бакалаврын сургалтанд хамруулан төгсөв. Бүх шатны соёлын байгууллагын мэргэжилтэй боловсон хүчний хангалт 56.5 хувьд хүрч өмнөх оныхоос 4 хувиар нэмэгдлээ.

Соёл, Спорт, Аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт:

2014 онд Соёлын 19 байгууллагын материаллаг баазыг сайжруулах, ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлэхэд ССАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар 5 сумын соёлын төвд “Мини кинотеатр”, зөөврийн аппаратур техник, тоног төхөөрөмж, 8 соёлын төвд оффисийн ширээ, аймгийн нийтийн номын сан болон сумдын Соёлын төвийн номын санд нийт 54,6 сая төгрөгийн номын сангийн

стандарт тавиур, Музейд камер, дохиололын систем, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор 11,9 сая төгрөгийн сейф, тавилга, иж бүрэн компьютер олголоо. Өв соёлын хүрээлэнгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Алтан өв” хөтөлбөрөөс 22,6 сая төгрөгийн, музейн дотоод урсгал засварт ОНХС-аас 3 сая төгрөг, ХДТеатрт ССАЖЯ-ны Соёл урлагийг дэмжих сангаас 66 сая төгрөг, ОНХС-гаас 95 сая төгрөг, Жаргалант сумын ОНХС-гаас 15 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдлээ.

2015 онд Соёл, спорт аялал жуулчлалын чиглэлээр хийгдэх ажил:

Соёлын салбарын зорилт: “Үйлчилгээний чанарыг дээшлүүлж, үйлчлүүлэгчлүүгээ хандсан жил” болгох зорилт тавин ажиллаж байна. Мөн энэ жил дараах ажлыг хийхээр төлөвлөж байна.

1. Музей, Өв соёлын хүрээлэнгийн үзмэрийг баяжуулж, ардын зан үйлийг төлөвшүүлэх ажлыг өргөжүүлнэ.

2. Улаанбаатар хотод Ховд аймгийн соёлын өдрүүдийг зохион байгуулна.

3. Номын сангуудын фондыг орчин үеийн шинжлэх ухаан, технологийн мэдээлэл, мэдлэг агуулсан номоор баяжуулан цахим номын сангийн үйлчилгээг өргөжүүлнэ.

5. Олон үндэстэн, ястны соёлын өвийг хадгалж хамгаалах, судлан сурталчлах, нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Алтан өв” хөтөлбөрийг хэрэгжүүлж, туулийн наадам, Монголын үндэсний уламжлалт бие биелгээний наадам зохион байгуулна.

6. Цэцэг, Мөст, Чандмань, Жаргалант сумдын соёлын өдрийг зохион байгуулна.

7. Үенч суманд соёлын төвийн барилгын ажлыг гүйцээж, ашиглалтад оруулна.

8. Түүх соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг фото болон цахим бүртгэлд бүртгэлжүүлэх ажлыг хийж, бүртгэл мэдээллийн сан бий болгоно.

9. Мэргэжлийн урлагийн байгууллагыг “Гэгээн Муза” олон улсын уралдаанд оролцуулна.